

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АЙМГУУДЫН ЗДТГ

2017 ОНЫ 3 ДУГААР САРД


Шилэн дансны тухай хуулийн дагуу 21 аймгийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ын нийтэд ил тод болгох ёстой мэдээллүүдээс зургааг нь сонгон авч 2017 оны 3 дугаар сарын туршид хэрхэн ил тод болгож байгааг ажиглав. Энэхүү ажиглалтыг орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд хийж гүйцэтгэлээ.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН



Өмнөх сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 11 аймгийн ЗДТГ бүрэн мэдээлж байсан бол 3 дугаар сард 8 болж буурчээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу аймгуудын ЗДТГ-ын 2017 оны 3 дугаар сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2-ыг үзнэ үү).



Тайлбар: 1 🏠 = 10%

АЙМГУУДЫН ЗДТГ-ЫН НИЙТЭЛСЭН ГҮЙЛГЭЭ БА ТҮҮНД ХАМААРАХ ШИЙДВЭРҮҮД



■ Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний тоо
■ Холбогдох шийдвэрийн тоо

(Тайлбар 1-ийг үзнэ үү)

ХУДАЛДАН АВАЛТ БА ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2017 оны 3 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Баян-Өлгий, Өвөрхангай аймгуудаас бусад аймгийн ЗДТГ хуулийн хугацаанд нь буюу 4 дүгээр сарын 8-ны дотор ил тод болгожээ.
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг Өвөрхангай, Дундговь, Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Ховд зэрэг зургаан аймгийн ЗДТГ нийтэлжээ. Мэдээлэл нийтлээгүй зарим ЗДТГ “тухайн сард цалингаас бусад 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт хийгдээгүй” гэсэн тайлбар өгчээ.
- Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зөвхөн таван аймгийн ЗДТГ хугацаанд нь нийтэлжээ. Харин 2 дугаар сард Хэнтий аймгийн ЗДТГ, 3 дугаар сард Архангай, Булган аймгийн ЗДТГ уг төлөвлөгөөг хугацаа хоцорч нийтэлсэн бол бусад аймаг ил болгоогүй хэвээр байна.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт болон гүйлгээний тоог гаргахдаа ЗДТГ-ын шилэн дансанд нийтлэгдсэн мэдээллээс зөвхөн үндд хамааралтайг түүвэрлэж авсан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 3 дугаар сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас
- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мониторингийн дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.